

АРХАНГАЙ АЙМГИЙН ХӨТӨЧ НОМ



АРХАНГАЙ

АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА МЭДЭЭЛЭЛ

БНМАУ-ын Бага хурлын 1931 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 5 дугаар хурлын тогтоолоор 5 аймгийг 13 аймаг болгожээ. Ингэснээр 1930 оны эцсээр 71 сум, 16 хошуутай байсан Цэцэрлэг мандал аймаг 35 сумтай Архангай аймаг болон зохион байгуулагдав.

Аймгийн төв: Цэцэрлэг хот

Хэдэн сумтай: 19, 101 багтай

Нутаг дэвсгэрийн хэмжээ: 55,314 км²

Хүн ам: 94,923 (2017 он)

Угсаатан: Халх

Малын тоо толгой: 52917.7 сая (2017 он)


Утасны код: +976 (0)133

Шуудангийн дугаар: 65000

ТХ-ийн улсын дугаар: AP

Цахим хуудас: www.arkhangai.gov.mn

Аймгийн бүх нутаг далайн түвшнээс 1200-3600 метр өндөрт өргөгдсөн. Хангайн нурууны салбар уулс, ойт хээр, тал хээрийн бүсээс бүрдэнэ. Тус аймгийн нутагт Суварга хайрхан, Цогт сүмбэр, Хутаг, Гялгар, Харлагтай, Хан-Өндөр, Баянбайшир, Дулаан хан, Бүрэн хан, Но нхангай, Халзан Бүрэгтэй зэрэг өндөр уулс, Бөхөн шар, Чингэлтэй, Тарвагатай, Бугат, Гичгэнэ, Тамирын өвч битүү ой тайгаар хучигдсан уул нурууд, Тамч, Тонгорог, Хөл сая, Хайрхан, Замт, Эг, Загастай, Хилзах, Согоот, Солонгот, Бумбат, Цагаан даваа зэрэг алдарт их даваанууд, Хонгорж, Тоглох, Хөшигт, Өгийн уудам тал, Хаалга, Мандах, Хануй, Хүнүй, Хөшөөт, Цайдам, Донгойн өргөн хөндийнүүд байдаг. Хөрсний бүтэц нь их төлөв ойт уулсын саарал, хар шороон хөрс, уулын хар хүрэн хөрс, уулын ам хөндийн хар бараан хөрстэй хосолсон хүрэн, хар хүрэн хөрс, нэлээд хэсгийг тал хээрийн хүрэн, цайвар хүрэн хөрс, нуга, намгийн хар хөрс, багахан хэсгийг уулын хяр хад, асга, ялимгүй хэсгийг цасан дорх хөрс эзэлнэ. Дэлхийн улаан номонд бичигдсэн дархан цаазат хулан, ирвэс ч байдаг.



ЦЭЦЭРЛЭГ

ХОТЫН ТУХАЙ



1922 онд засаг захиргааны хувиараар аймгийн чуулган даргын захиргааг Цэцэрлэг мандал аймгийн яам болгож, Заяын шавийг Эрдэнэ Булган уулын хошуу болгон өөрчилж Цэцэрлэг мандал аймгийн төв нь болсон. 1952 онд Булган сумын 7, 10, 11, 12 дугаар багийг нэгтгэн хороо, захиргаа буюу аймгийн төв, 1961 онд Цэцэрлэг хот, 1992 онд Эрдэнэбулган сум болон өөрчлөн зохион байгуулагсан. Цэцэрлэг хот нь ерөнхий боловсролын 7 сургууль, хүүхдийн 7 цэцэрлэгтэй, театр, зочид буудал, нэгдсэн болоод хувийн хэвшлийн эмнэлэг, Монгол Улсын Боловсролын их сургуулийн харьяа Багшийн сургууль, хувийн хэвшлийн сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдтэй.

Өрхийн тоо: , 5524

Хүн амын тоо: 20338



АРХАНГАЙ АЙМГИЙН

ЭРТНИЙ НҮҮДЭЛЧДИЙН ӨЛГИЙ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБОО

Аймгийн аялал жуулчлалын холбоо

Архангай аймгийн "ЭРТНИЙ НҮҮДЭЛЧДИЙН ӨЛГИЙ" аялал жуулчлалын холбоо нь 2014 онд байгуулагдсан бөгөөд тус аймагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хувь хүмүүсийг хариуцлагатай, тогтвортой аялал жуулчлал эрхлэх, орон нутгийн иргэдийн амьжиргаанд тус дэм болоход нэгдсэн зохион байгуулалттайгаар ажиллах зорилготой. Мөн олон улсын болон дотоодын үзэсгэлэн яармаг, чуулга уулзалт, сургалт семинарт хамтран оролцож гишүүн байгууллагуудын бизнесийн харилцаа холбоог хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

ҮЗМЭРҮҮД

АРХАНГАЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ЧУЛУУТЫН ГОЛ

уулуутын гол нь Хангайн нурууны Гурван Ангархай уулын баруун хэсгийн араас эх авч Даваатын гол нэртэйгээр урсан хэд хэдэн гол горхиудыг нийлүүлэн авч Чулуут гол болон 415 км урсаж Идэр голын баруун гарт очиж нийлнэ. Усаа цуглуулах талбай нь 10750 ам.дөр.км, усны уналт нь 2000 м, гулдралын өргөн нь 80 м, гүн нь 3 м, урсгалын хурд нь 2 м/с, усны жилийн урсан өнгөрөлт нь 25 шоо м хүрнэ.

Хөндий, гулдрал нь хад чулуу ихтэй учраас Чулуут гол гэдэг нэртэй болжээ. Чулуут гол нь Тээлийн голын (их замын гүрнээс доош) адгаас доош Ацатын горхины адаг хүртэл 100 орчим км газарт 60-60 орчим м гүн хүрмэн чулуун хавцал үүсгэж урсана.

Энэ хүрмэн чулуу нь Хорго орчмын галт уулын дэлбэрэлтийн үед урсан ирсэн магмын бүтээгдэхүүн юм. Чулуут голд Ихжаргалант гол, Хүрэмт гол, Туул гол, Ажирга гол, Хангал гол, Бумбат гол, Өлзийт гол, Мөрөн гол, Уужим гол, Даага гол, Ацат гол, Тээл гол, Суман гол зэрэг олон гол горхи цутгана. Чулуут голын савд хойд өргөрөгийн 47°49', зүүн уртрагийн 100°15'-ын солбицолд гидрокарбонат сульфат натрийн найрлагатай, үе мөч, мэдрэлийн өвчнийг анагаах чанартай халуун, бүлээн рашаан оршдог. Энэ голын савд Чулуут, Тариат, Жаргалант, Цэцэрлэг сумдын нутагт орших Чулуут голын хадны зургийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.



ҮЗМЭРҮҮД

АРХАНГАЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ХОРГО

Архангай аймгийн Тариат сумын төвд оршдог. 1965 оноос дархан цаазат газрын, 1994 оноос байгалийн цогцолборт газрын зэрэглэлээр улсын тусгай хамгаалалтад авчээ. Одоогоос 9 мянга орчим жилийн өмнө дэлбэрч байгаад унтарсан галт уул юм гэдгийг манай газар зүйн эрдэмтэд тогтоожээ. Өөрөөр хэлбэл энэ нь манай орны унтарсан галт уулуудын дотроос хамгийн сүүлд унтарсан галт уул төдийг үй жаахан хэтрүүлбэл уур нь савсаж байгаа “шинэхэн” уул. Хорго уул нь далайн төвшнөөс дээш 2240 метрийн өндөр бөгөөд Хорго уулаас оргилон гарсан халуун хайлмал бодис магма нь газрын уруу даган зүүн тийшээ Суман, Чулуут голын хөндийгээр зуугаад километр урссан байдаг. Энэ замаар барагцаалбал 10-20 километр өргөн хөндийгээр урссан магма нь 40-50 метр зузаан хүрмэн чулуун хучилга болон царцсан байж магад гэж эрдэмтэд таамагласан байдаг. Мөн Хорго уулыг 2 удаа дэлбэрсэн гэж ч ярилцдаг. Уулын тогооны амсар нь 50 градус орчим налуу, 100 орчим метр гүнзгий 300-400 метр диаметртэй дугуй хэлбэртэй. Хоргын тогоон дотор нь сандал, ширээ шиг том том хүрмэн чулуу ундуй сундуй хөглөрч байдаг учир явахад бэрхтэй. Тогоон дотор зөвхөн баруун талаас нь л маш болгоомжтой орж болно. Хорго уулаас урагш зургаан километр орчимд Суман голын зүүн гар талд Тариат сумын төвөөс баруун урагш 3 орчим километр зайтай газарт чулуун гэр гэж сонирхолтой үзмэр бий.



ҮЗМЭРҮҮД

АРХАНГАЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ТЭРХИЙН ЦАГААН НУУР

Тэрхийн Цагаан нуур нь Хорго уулаас баруун тийшээ далайн төвшнөөс дээш 2060 метр өндөрт оршино. Тэрхийн цагаан нуур нь 16 километр урт, 6 километр өргөн, 61 ам километр талбайтай 20 метр гүн цэнгэг устай урсгал нуур. Хорго уул дэлбэрэхэд оргилон гарсан халуун хайлмал бодис нь Тэрхийн голын хөндийгөөр дүүрч, тэр голын урсгалыг хаахад Тэрхийн цагаан нуур үүсчээ. Өөрөөр хэлбэл энэ нуур 9 мянган орчим жилийн настай ажээ. Дотроо хэд хэдэн аралтай нуурын толгой гэдэг арал дээр нь зундаа гогой гэдэг шувуу үүрээ засан өндөглөдөг. Нуурын хойгуур хүрээлэн орших Тарвагатайн нуруунаас эх авсан Нарийн гэх зэрэг гол горхи энд цутгадаг. Мөн гутар, зэвэг, хадран зэрэг олон зүйл загастай. Харин сүүлд Хорго-Тэрхийн цагаан нуурын 773 ам километр талбайг улсын хамгаалалтад авчээ.



ҮЗМЭРҮҮД

АРХАНГАЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

СУВРАГА ХАЙРХАН УУЛ

Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт оршдог бөгөөд далайн түвшнээс дээш 3117 метр өргөгдсөн, Хангайн уулархаг мужид багтах уул юм.

Суврага хайрхан уул нь хормойгоороо ой модоор хучигдсан, нүцгэн оройтой, ноён оргилоосоо доохно, уулын энгэр талдаа тунгалаг нууртай, завилаад сууж буй хүн шиг сонин тогтоц бүхий уул юм. Нутаг усныхан болон ойр орчмын хүмүүс энэ уулыг эртнээс тахин шүтэж, эр хүн жил бүр ууланд гарч хийморио сэргээдэг эртний уламжлалтай юм.

Суврага хайрханы урд элэгнээс Орхон, араас нь Урд Тамир, зүүн суганаас нь Цэцэрлэгийн голууд эх авдаг, Хангайн нурууны усны гол хагалбар газар юм.

Суврага хайрхан уулнаас салбарласан өвөр талдаа Боржин хад, Байц цохио, Нүцгэн орой, хүнх, хуниас бүхий Солбидог, Жимгэр, Хошгот, Тонгорогийн их, Бор, Цагаан өргөө зэрэг олон сүрлэг нугууд салбарладаг бөгөөд эдгээр уулсаас Тонгоргийн гол, Хошготын гол, Жимгэрийн гол, Хөрвөөлгийн гол, Өлзий Тээлийн гол зэрэг түргэн урсгалтай, үхэр чулуутай бэсрэгхэн голууд гол төлөв их ганга, анаг хавцал дундуур боргио үүсгэн урсч Орхон голын эх сав газрыг бүрдүүлдэг ба Улаан цутгалан хэмээх хүрхрээг үүсгэн Өвөрхангай, Булган, Сэлэнгэ аймгийн олон ард иргэдийг ундаалж, амьдрах усны эх болдог байна.



ҮЗМЭРҮҮД

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ТАМИРЫН ГОЛ

Тамир гол нь Монголын нууц товчоонд ч Тамир нэрээрээ гардаг. Хангайн нурууны хэсэг Гурван Ангархай, Цохиотын нуруунаас эх авч урсана. Хойд, Урд Тамир гол нийлсний дараа Тамир гол нэртэй болно. Ингэж Гурван-Тамир гол гэдэг нэр гарсан. Урд Тамир голын эхээс тооцвол 280 км урт, усаа цуглуулах талбай нь 13,100 км².

Хойд Тамир дээд хэсэгтээ эгц хажуутай нарийн хөндийгөөр урсдаг. Баруун гарын эрэг нь хар модон ойтой. Урд тамир гол нь дээд хэсэгтээ Хошгот, Архошгот зэрэг голуудыг нийлүүлэн авч урсдаг, түргэн урсгалтай, жинхэнэ уулын гол юм. Тамирын хөндий нь их өргөснө. Голдрилын өргөн нь 40 - 70 м, гүн нь 2-3 м, урсгалын хурд нь 2 м/с хүрнэ. Тамирын голын савд төмрийн хүдрийн баялаг орд бий. Урд Тамирын голоос эртний төрмөлийн эриний түүх дурсгалын зүйл олддог.



ҮЗМЭРҮҮД

АРХАНГАЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

БУЛГАН УУЛ

Архангай аймгийн Цэцэрлэг сумын дэргэд оршдог бөгөөд байгалийн үзэсгэлэнт байдлыг нь харгалзан 1965 онд 1.8 мян. га талбай бүхий газрыг хамгаалалтад авсан байна. Булган уул нь Хангайн муж, түүний ландшафтын нийтлэг төрхийг төлөөлж чадахгүй учраас байгалийн үзэсгэлэнт байдал, түүхийн дурсгалт зүйлс байдгийг нь харгалзан УИХ-ын 1995 оныг 26 дугаар тогтоолоор байгалийн дурсгалт газар болгосон. Нийтдээ 1840 га талбайтай.

Дурсгалт газрын дундуур зүүн хойш чиглэсэн гол их нуруу хоёр Тамирын усны хагалбар болох бөгөөд энд Аригийн нуруу, Хамрын нуруу, Хялалзах, Мурилзахын нуруу зэрэг боржин хаднаас тогтсон олон нуруу, зүүн өмнө орших Таван цохионоос эгц хойш Цагдуулт (1940м) боржин хадат уул, Малгай (2143 м) зэрэг өндөр уултай. Булган уулын зүүн хормойд орших Жамганы рашаан, баруун хэсэгт Ганц модны рашаан гэх мэт рашаан ус бий.

Булган уул ой мод, хадлан бэлчээрийн ургамлаар нэн баялаг тул тус орны ой хөвч, ойт хээрийн бүсэд тохиолддог ургамлын ихэнх зүйл ургана. Энд гүзээлзгэнэ, хад тошлой, самар, таван салаа, тарваган шийр, сөд, царван, алтан гагнуур, бамбай, ганга, нохойн хошуу, гишүүнэ, хунчир зэрэг эмийн ургамал ургана. Мөн цагаан төмс, мэхээр, бүүргэнэ, гонид зэрэг хүнсэнд хэрэглэгддэг ургамалтай.



ҮЗМЭРҮҮД

АРХАНГАЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ТАЙХАР ЧУЛУУ

Тайхар чулуу нь Архангай аймгийн Их тамир сумын нутагт Тамирын голын хөвөөнд орших бүдүүн ширхэгт боржин чулуун цохио. VII-IX зууны бичээс дурсгалын зүйл ихтэй.

Тайхар чулуу нь газрын байрлалын хувьд урдуур хойгуур нь өндөр дэнж(хар эрэг)-тэй, харалдаа ард нь тайхар чулууруу харсан хадан хясаа бүхий намхавтар уултай(улаан толгой) бөгөөд олон жилийн өмнө урд хойд хоёр эргийн хооронд их хэмжээний ус урсдаг, арын уул нь тайхар чулууг хүртэл урагшаа үргэлжилсэн байрлалтай байсан. Энэхүү чулуун хөшөөний тухай олон домог, шинжлэх ухааны тайлбарууд байдаг.

Эрт цагт аварга могой газраас цухуйн хамаг амьтныг залгин гамшиг тарьж байх үед Бөхбилэг гэдэг хүчтэн Булган уулаас Тайхар чулууг авч үүрч Цагаан даваагаар давж тэр уулын оройгоос Могойн толгой руу шидэн даржээ. Ингээд энэ чулууг эхлээд Тархи чулуу гэж нэрлэдэг байсан нь хожим хувирч Тайхар чулуу гэх болжээ. Бөхбилэг уг чулууг үүрч явахдаа Шивэрт хэмээх аманд хэсэг амарсан гэнэ. Тэгтэл чулуу тавьсан газар нь цөмөрч ус олгойдон гарсан гэдэг. Ингэж шивэртийн халуун Рашаан үүссэн домогтой. Мөн могойн сүүл цухуйсан газрыг Шивэрт гэж нэрлэжээ.



БУСАД ҮЗМЭРҮҮД



ХАР БАЛГАС

Төв азийн нүүдэлч ард түмний дунд МЭ VIII-IX зууны үед ээлжит төр улсаа байгуулан 100 орчим жил оршин тогтнож байсан Уйгурын хаант улсын нийслэл Орду балык буюу нутгийнхны нэршлээр Хар балгас гэдэг их хотын нуранхай Архангай аймгийн Хотонт сумын нутагт, Хархориноос зүүн хойш 40 км-т Орхоны хөндийд байдаг.

Уйгурын Яглакар овгийн Ноён Пэйло 744 онд биеэ Күтүлүг Билгэ Күл хаан (744-747) хэмээн өргөмжилж хаан ширээнд суусан байна. Түний удирдсан хүч 745 онд Түрэгийн хаант улсыг бүрмөсөн бут цохиж Уйгур улсыг байгуулав. Тэрээр 751 онд Орхоны хөндийд Орду Балык буюу Балыклик (Хар балгас) хэмээх хот цогцлон байгуулж улсын нийслэл болгожээ. Энэхүү хот нь Хөх Түрэгийн хаант улсын нийслэл хотын туурин дээр байгуулагдсан гэж үздэг. Хар балгасны цайзат хэрэм хэмжээгээр ихийн /0,6x0,6 км/ дээр нэлээд нурсан боловч одоо арваад метр өндөр, цайз нь 12 м, хэрмийн төвд байсан том цайз /хараат/ 14 м байна.

ӨГИЙ НУУР

Архангай аймгийн Өгийнуур сумын нутагт оршдог 25 хавтгай дөрвөлжин километр талбайтай нуур. 7 километр урт, 5 километр өргөн. Хамгийн гүнзгий газартаа 15 метр орчим. Далайн төвшнөөс дээш 1337 метр бөгөөд Хойд мөсөн далайн ай савд багтдаг.

Өгий нуур баруун талаасаа Хөгшин Орхоны усаар тэжээгдэж, баруун хойшоо Хоолойн гол гарч Орхон голд цутгадаг. 11 дүгээр сараас 5 дугаар сар хүртэл мөсөн бүрхүүлтэй байдаг. Улаан нүдэн, цурхай, зэвэг, алгана, гутаар, бэс загас, мөнгөлөг хэлтэг, цурхай зэрэг Орхон голын савд байдаг 14 зүйл загас, 27 зүйл хөвөгч ургамал, 48 зүйл хөвөгч амьтан байгааг судлаачид тогтоожээ. Энэ онцлогийг даган 150 орчим төрлийн усны шувууд цуглардаг нуур юм. Хошуу галуу, халбаган хошуут зэрэг ховор шувууд байдаг учраас зүүн хойд Азийн галуу, нугасны овгийн шувуудыг хамгаалах олон улсын сүлжээнд бүртгэгджээ. Энэ нуур тахилгатай тул эмэгтэй хүн орохыг цээрлэнэ. Өгий нуурын ус намгархаг газрын экосистемийг хамгаалахын тулд 1971 онд хуралдсан олон улсын хуралдаанаар Рамсарын конвенцид бүртгэжээ.

ЦЭНХЭРИЙН ХАЛУУН РАШААН

Архангай аймаг нь үзэсгэлэн бүхий нутагтай, гайхамшигтай сайхан байгальтай газар юм. Архангай аймгийн байгалийн гайхамшгуудын нэгд Цэнхэрийн халуун рашаан зүй ёсоор тооцогдно. Архангай аймгийн Төв Цэцэрлэг хотоос зүүн тийш 25 км-т Цэнхэр сум оршдог. Цэнхэрийн халуун рашаан хэмээн алдаршсан энэхүү рашаан нь Цэнхэр голын хөвөөнд байх ажээ. Цэнхэрийн халуун рашаан нь Цэнхэр сумын төвөөсөө баруун урагшаа 16 км зайтай, оршино. Тэнд "Цэнхэр жигүүр", "Шивээт манхан", "Дуут" гэх мэт амралтын газрууд байдаг. Гадаад болон дотоодын аялагчид, амрагчид их очдог. Цэнхэрийн халуун рашаан нь ходоод, бөөр, элэг, цөс, зүрхний үйл ажиллагаанд их сайн. Гэхдээ тус рашаанд 15-20 минут ороход хангалттай. Илүү удвал дотор эвгүйрхэх, толгой эргэх гэх мэт үзэгдлүүд ажиглагдана. Халуун рашаан нь гидрокарбонат, хүхрийн рашаан юм. Тиймээс зарим хүмүүс арьсанд сайн гэж үздэг.



БУСАД ҮЗМЭРҮҮД

БИЛГЭ ХААНЫ ЦОГЦОЛБОР


Архангай аймгийн Хашаат сумын Цайдам бригадын нутагт Өгий нуураас баруун урагш 36 км, Хархориноос хойш 47 км зайд Хөгшин Орхон голын зүүн эрэг, Цайдам нуурын баруун өмнө оршдог. Эл дурсгал нь Хөшөө цайдмын дурсгал, Орхоны хөндийн дурсгал, Культегины бичээс, Билгэ хааны дурсгал гэх мэтээр нэрлэгдэн 100 гаруй жилийн турш судлагдсаар иржээ. Элтерэс хааны хүү Билгэ бол Түрэг улсын сүүлчийн хаан бөгөөд 19 жил улсаа удирдсан юм. Түүний дүү Культегин нь ухаалаг, авъяаслаг цэргийн жанжин байгаад 731 онд 49 насандаа таалал төгсчээ. Культегин ах Билгэг хаан ширээнд суухад тууштай дэмжиж түүний төлөө хүчин зүтгэсэн түүхтэй. Билгэ хаан дүүгийнхээ дурсгалд зориулан тахилын цогцолбор, шүтээний сүмийг 732 оны 8 дугаар сарын 1-нд босгуулжээ. Цогцолборын урт 67 метр, өргөн 29 метр, 1 метр зузаан тоосгон хэрэмтэй, түүний гадуур шуудуугаар хүрээлэгдсэн, хэрмийн доторхи сул зайг бүхэлд нь 32 x 32 x 6 см хэмжээтэй тоосгоор бүрсэн байжээ. Цогцолборын голд наран ургах зүгт харуулан Культегины гэрэлт хөшөөг байрлуулсан бөгөөд мэлхий чулуун суурийн хамт өндөр нь 383 см, өргөн нь 132 см, зузаан нь 46 см юм.



ЧОЙДОГИЙН БОРГИО

Архангай аймгийн Тариат сумын нутагт Чулуут-Суман голын бэлчирээс холгүйхэн орших 1 метр өндөртэй бяцхан хүрхрээг Чойдогийн боргио гэнэ. Энд Чулуут гол болон Сэлэнгийн сав газрын загас цугларч боргионы өөд үсрэн дүүлэх нь нэн сонирхолтой.

Урьд цагт энэ нутагт Чойдог хэмээх сайн загасчин байж. Намар орой загас урсгал сөрж, боргио өөд цовхчин давдаг байна. Яг ингэж цовхчих үед нь Чойдог гуай загасыг уургалж барьдаг байжээ. Үүнээс хойш уг боргиог "Чойдогийн боргио" гэж нэрлэх болсон гэдэг. Алжаал ядаргаа тайлдаг өвөрмөц тогтоцтой газар.



ШИВЭРТИЙН ХАЛУУН РАШААН

Архангай аймгийн Батцэнгэл сумын Дарьхинтын хөндийн байгалийн үзэсгэлэнт газар байрладаг. Цэцэрлэг хотоос зүүн хойшоо 35 км, Улаанбаатар хотоос 465 км-д оршдог. Нэг дор 250 хүн хүлээн авах хүчин чадалтай, 150 хүний ресторан, 50 хүний VIP room, 250 хүний хурлын болон бүжгийн заалтай. Жилийн дөрвөн улиралд үйл ажиллагаа явуулдаг. Уг цогцолбор нь тохилог, таь тухтай бүтэн, хагас люкс, энгийн гэсэн 3 зэрэглэлийн өрөөтэй. Багц үнэнд шавар болон рашаан жмчилгээ, зүү төөнө, бариа засал, физик эмчилгээ, эмийн бус эмчилгээнүүд болон тухайн өдрийн хоол багтана. Байгалийн ундарга бүхий 68 градусын хүхэрлэг, халуун рашаан, "Нохой унадаг" нуурын халуун шавраар мэдрэл, үе мөч, арьс харшил болон бусад өвчин эмгэгүүдийг сувилж эмчилнэ.



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД

ТЭРХИЙН ЦАГААН НУУР ОРЧМЫН БААЗУУД



МАЙХАН ТОЛГОЙ

- 📍 Архангай аймгийн Тариат сум
- ☎ 77119730
99093339
- 🌐 www.mongoliatrip.com
- 📄 lounge.resistors.showroom
48°10'47"N, 99°45'46"E



ИХ ХОРГО

- 📍 Архангай аймгийн Тариат сум
- ☎ 99089496
91609099
- 🌐 www.khorgo.mn
- 📄 successors.teams.dedicatory
48°10'55"N, 99°48'43"E




ХОРГО ӨРГӨӨ

- 📍 Архангай аймгийн Тариат сум
- ☎ 99990079
99170079
- 🌐 concurrency.telephone.distrusting
48°10'50"N, 99°48'46"E



ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУД

ЦЭЦЭРЛЭГ ХОТЫН ЗООГИЙН ГАЗРУУД




RICHLAND

Архангай аймгийн
Цэцэрлэг хот

99707067

Монгол, Европ, Ази хоол
www.facebook.com/richlandhotel

lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E



FAIRFIELD CAFE


FAIRFIELD

Архангай аймгийн
Цэцэрлэг хот

70333036

Cafe and bakery
www.facebook.com/fairfield

lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E



НАРАН

Архангай аймгийн
Цэцэрлэг хот, 3 баг

70333000 99332900

Монгол, Европ, хүргэлт
www.facebook.com/naranhotel

lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E

ЭВЭНТ БАЯР НААДМУУД

МОНГОЛ САРЛАГ ФЕСТИВАЛ

Энэхүү арга хэмжээ нь гадаад дотоодын жуулчдын сонирхлыг зүй ёсоор татаж, улмаар тэдэнд үзүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, сарлагийн гаралтай түүхий эдийн ашиг шимийг сайжруулах, сурталчлах зорилготойгоор зохион байгуулагддаг юм.

ХУГАЦАА:

Жил бүрийн 7-р сард

ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ГАЗАР:

Архангай аймаг, Их тамир сум, Тайхарын ард Сарлагын баяраар дараах төрлийн тэмцээнүүд явагддаг байна.

- Багийн тэмцээн
- Сарлаг бугуйлдах
- Дүүгүүр шидэх
- Сарлагийн шилдэг бүтээгдэхүүн шалгаруулах
- Сарлаг булгиулах
- Сайхан сарлаг шалгаруулах

Мэдээлэл авах утас: 95851400,
99370393



ЗАЯЫН ХҮРЭЭНИЙ ӨВЛИЙН БЭСРЭГ НААДАМ

“Булган ууланд зул өргөх ёслол болон мөсний шагайн харваатай нэгтгэн Заяын хүрээний өвлийн бэсрэг наадам эвент арга хэмжээг өвлийн аялал жуулчлалыг дэмжих чиглэлээр тогтмол зохион байгуулж байна. Дэлхийд зул өргөдөг цор ганц уул бол Архангай аймгийн төвд байх Булган уул юм. Булган ууланд 400 жилийн өмнөөс эхлэн зул барьж эхэлжээ.

ХУГАЦАА:

Жил бүрийн 1 сарын сүүлээр

ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ГАЗАР:

Архангай аймгийн төв Дараах арга хэмжээнүүд зохион байгуулагддаг

- Кирлингийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн
 - Сонирхогчдын Мөсний шагайн тэмцээн
 - Буухиа тэмцээн
 - Сонирхогчдын мөсөн сурын харваа
 - Хийн буудлага
 - Булган ууланд зул өргөх
 - Шилдэг мөсөөр хийсэн бүтээл шалгаруулах
- мэдээлэл авах утас: 95851400,
99370393



ЭВЭНТ БАЯР НААДМУУД

ОРХОНЫ ХӨНДИЙН АДУУЧДЫН БАЯР

Монгол брэнд гэдэг утгаараа үе дамжин мал маллаж, малын ашиг шимээрээ амьжиргаагаа залгуулахын хирээр өөрсдийгөө баясгадаг байсан уламжлал нь уралдаан тэмцээний хэлбэрт шилжин хөгжиж байгааг харуулан орон нутгийн иргэдийг дэмжих, идэвхижүүлэх мөн аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож байгаагаараа онцлогтой.

ХУГАЦАА:

Жил бүрийн 8 сарын 7

ЭВЭНТ БОЛОХ ГАЗАР:

Хашаат сумын ЦАЙДАМ жуулчны бааз

Мэдээлэл авах утас: 99168971,
99236888



ОРХОНЫ ХӨНДИЙН БЯЦХАН 99 БААТРЫН АЯЛАЛ

Монголын нүүдэлчин амьдралтай гэр бүл дэх хүүхдийн оролцоо, малчин гэр бүлийн амьдрал, хамтын хөдөлмөр, Монгол наадмын нийтийн оролцоо дэг жаягийг харуулан орон нутгийн иргэдийг дэмжих, идэвхижүүлэх зорилготой.

Энэхүү арга хэмжээ нь UNESCO-д түүх соёлын дурсгалт газраар бүртгэгдсэн Орхоны хөндийд зохиогдон хүүхдийн бөхийн барилдаан, сур харваа, дааганы уралдаан, урлагийн тоглолт, шилдэг баатрын хувцас, шилдэг гийнгоочин шалгаруулах зэрэг хөтөлбөртэй

ХУГАЦАА:

Жил бүрийн 8 сарын 5

ЭВЭНТ БОЛОХ ГАЗАР:


Хашаат сумын "Цайдам" жуулчны бааз

Мэдээлэл авах утас: 99168971,
99236888



АРХАНГАЙН АЯЛАЛЫН МАРШРУТ

АРХАНГАЙ АЙМАГТАЙ ТАНИЛЦАХ АЯЛАЛ



Аялагчдын хүсэлтээр үзэх үзвэр, байрлах газар, хоногийн-тоог өөрчилж болно.

АРХАНГАЙН АЯЛАЛЫН МАРШРУТ

АРХАНГАЙГААР АЯЛАХ МӨРГӨЛИЙН АЯЛАЛ

УБ-Элсэн тасархай-Хархорин-Хотонт-Цэнхэр-Архангай аймаг-Хорго-Гэсэр-Чойдогийн боргио-Их улаан шивэрт-Тайхар-Өгийнуур-УБ



ӨДӨР 4

Гэсэр ламын
үзмэр

Хорго - Гэсэр ламын үзмэр

Өдрийн хоол /боолтын хоол/
Гэсэр ламын үзмэрээс
Далайван жуулчны бааз

Байрлах жуулчны бааз:

Далайван жуулчны бааз
Өглөө, өдөр, оройн хоол



Хорго, Тэрхийн
Цагаан Нуур

Далай ван - Чойдогийн боргио - Тайхар чулуу

Байрлах жуулчны бааз: /Тайхар бааз,
Тунгалаг тамир, Эх Байгаль/
Өглөө, өдөр, оройн хоол



ӨДӨР 5

Тайхар
чулуу



Цэцэрлэг хот

Цэнхэрийн халуун рашаан - Цэцэрлэг хот

/Заяын хүрээний хийд,
Булган Хайрхан, Музей
Өдрийн хоол /Fairfield,
Майдар сан, Хавтгай мод/
Архангайгаас Хорго /
Хоргын тогоо, Шар нохойн
там, Ганц хүний агуй

Байрлах жуулчны бааз:

Тэрхийн цагаан нуур/
Майхан толгой, Тэрх Энх,
Их хорго, Хорго Өргөө,
Бадмаараг, Далай Ван./
Өглөө, өдөр, оройн хоол

Хотонт - Цэнхэрийн халуун рашаан

Байрлах жуулчны бааз: Цэнхэр
/Дуут респорт, Шивээт манхан, Хангай
респорт, Алтан нутаг, Цэнхэр жигүүр/
Өглөө, өдөр, оройн хоол



ӨДӨР 2

Цэнхэрийн
Халуун Рашаан



Хотонт



ӨДӨР 6

Хөшөө Цайдам

Тайхар - Хотонтын хар балгас- Хөшөө Цайдам

Байрлах жуулчны бааз: Цайдам
Өглөө, өдөр, оройн хоол



Өгий нуур



Хөшөө Цайдам - Өгий нуур

Байрлах жуулчны бааз: /Хатан Өгий, Өгий
далай, Өгий тур, Өгий, Өгий хишиг/
Өглөө, өдөр, оройн хоол.
Өгийнуураас Улаанбаатар орно.



Өглөө Улаанбаатраас хөдлөн
Элсэнтасархайд өдрийн хоол иднэ.
Хархорин /Музей үзэх,
Эрдэнэ зуу хийд

Байрлах жуулчны бааз: Хотонт
сум Артхан зочид буудал
Оройн хоол
Өглөөний цай



ӨДӨР 1


Улаанбаатар



Элсэн тасархай



Хархорин



Аялагчдын хүсэлтээр үзэх үзвэр, байрлах газар, хоногийн тоог өөрчилж болно.